



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ /Дээд боловсролын диплом олгох журам/ 2006 оны 12 сарын 29 өдөр Улаанбаатар хот Дугаар 480 "Боловсролын тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, яамны нэгжийн дарга нарын зөвлөлийн 2006 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь: 1."Дээд боловсролын диплом олгох журам"-ыг нэгдүгээр, " ~~Бакалавр, магистр, докторын дипломын загвар~~"-ыг хоёрдугаар /Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2012 оны 01 дүгээр тушаалаар 2-р хавсралтыг хүчингүй болгосон/ хавсралтын ёсоор тус тус шинэчлэн баталсугай. 2.Энэхүү тушаалыг 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж, хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газар /М.Баасанжав/, Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/, Улсын мэргэжлийн хяналтын газрын Боловсрол, соёл, шинжлэх ухааны хяналтын улсын алба /Б.Энхбат/, их, дээд сургууль, коллежийн захирлуудад тус тус үүрэг болгосугай 3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Журам, маягт, загвар шинэчлэн батлах тухай" 2002 оны 355 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай. САЙД Ө.ЭНХТҮВШИН Улсын бүртгэлийн 2007 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 2674 дүгээрт бүртгэгдсэн Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2012 оны 01 дүгээр тушаалаар 2-р хавсралтыг хүчингүй болгосон